



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/538

Чингис хот

Зүрхний эмгэгтэй хүүхдүүдийн эмчилгээний
төлбөрт хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.4, 58.2.5, 58.2.20, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн Хуралдааны 2021 оны 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зүрх мартахгүй” төслийн хүрээнд зүрхний хагалгаанд орох зайлшгүй шаардлагатай 10 хүүхдийн эмчилгээний зардалд 50,000,000 (тавин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012654